

“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалтыг үндэслэн Үндэсний давхар даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулна.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Сонгон шалгаруулалтад орох хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет /маягт №1/;
- Доорх ерөнхий шаардлагын дагуу материал ирүүлэх;

НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. **Эдийн засаг, хууль эрхзүй, санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;** */Боловсролын түвшинг тодорхойлох баримт бичиг /диплом/-ийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/*
2. **Банк, санхүү, даатгалын салбарт 10-аас доошгүй жил удирдах албан тушаал хашсан туршлагатай байх, үүнээс даатгалын байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаал хашсан байх;** */Ажилласан жилийг тооцох Нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны бичилт бүрэн хийгдэж баталгаажсан хувийг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/*
3. **Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;** */Ажилласан жилийг тооцох Нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны бичилт бүрэн хийгдэж баталгаажсан хувийг ирүүлэх/*
4. **Бизнесийн болон ёс зүйн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;**
5. **Ял шийтгэлгүй байх;** */Цагдаагийн ерөнхий газраас “Ял шийтгэлийн тухай тодорхойлолт” авч ирүүлэх/*
6. **Даатгалын компанийн хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох этгээд бус байх;** */Улсын бүртгэлийн ерөнхий газраас холбогдох “Хуулийн этгээд бүртгэлтэй эсэх лавлагаа”-г гаргуулан авч ирүүлэх/*

Жич: Нэр дэвшигч нь гаргасан өргөдөл болон түүнд хавсаргасан бусад баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд худал мэдээлэл гаргасан тохиолдолд өргөдөл гаргаагүйд тооцож шалгаруулалтад оролцуулахгүй болохыг анхаарна уу.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ:

Сонгон шалгаруулалтад орох хувь хүмүүсийн хүсэлт, материалыг 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 11.00 цаг хүртэл доорх хаягаар хүлээн авна.

Монгол Улс, Улаанбаатар хот-142518, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, 5-р хороолол, 10Б байр, Бизнес тауэр, 20 давхар “Үндэсний давхар даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Ангар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ